



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Засгийн газрын “Журам шинэчлэн батлах тухай” 2020 оны 206 дугаар тогтоолын 3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны А/342 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Г.Доржханд (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

О.Отгонтуяа (Санхүүгийн албаны дарга)

Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Б.Орбиш (Нийгмийн ажилтан)

Г.Сарантуяа (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Г.Сугар (Эрх зүйн хөтөч)

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг удирдамжинд заасан заалт нэг бүрээр нарийвчлан гаргаж, үнэлэлт дүгнэлт өгч нэгтгэн, PDF файл үүсгэн 2023 оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтэст цахимаар хүргүүлэхийг Ажлын хэсгийн дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН